



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 08 сарын 13 өдөр

Дугаар 1298

Улаанбаатар хот

Сүхбаатар дүүргийн Монгол-Оросын
хамтарсан сургуулийн эргэлтийн бус
хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсэг, “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2019 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 13,444,795.0 /арван гурван сая дөрвөн зуун дөчин дөрвөн мянга долоон зуун ерэн таван/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан номыг акталж, данс бүртгэлээс хасахыг Сүхбаатар дүүргийн Монгол-Оросын хамтарсан сургууль /Ж.Соронзон/-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй номыг Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгаж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Сүхбаатар дүүргийн Монгол-Оросын хамтарсан сургууль /Ж.Соронзон/-д үүрэг болгосугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтэс /М.Энхболд/-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
 газрын даргын 2019 оны 08 сарын
 13 өдрийн 01/2019 дугаар тушаалын хавсралт



Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Сүхбаатар дүүргийн Монгол-Оросын хамтарсан сургууль

№	Эд хөрөнгийн нэр	Ашиглалтанд орсон жил	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ЭБХХХ Комиссын хурлын шийдвэр
1	Сурах бичиг	1940-2009	10-70 жил	ш	2,158	13,444,795.00	13,444,795.00			Сургалтын хөтөлбөрт хэрэглэгдэхгүй, хуучирсан, эрүүл ахуйн шаардлага хангахгүй	устгах
Номын фондын дүн					2,158	13,444,795.00	13,444,795.00	-	-		
Нийт дүн							13,444,795.00				
Актлах хөрөнгө							13,444,795.00				
Татан төвлөрүүлэх хөрөнгө							0.00				